


**Хүүхдэд зориулсан Библи  
танилцуулж байна**



**Есүс арван  
хоёр  
дагалдагчаа  
сонгосон  
нь**



**Зохиогч: Edward Hughes**

**Зураглаач: Byron Unger; Lazarus; Alastair Paterson**

**Найруулсан: E. Frischbutter; Sarah S.**

**Орчуулсан: Damdin Norolsuren**

**Бүтээсэн: Bible for Children**

**[www.M1914.org](http://www.M1914.org)**

**BFC**

**PO Box 3**

**Winnipeg, MB R3C 2G1**

**Canada**

**©2022 Bible for Children, Inc.**

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах  
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Есүс гайхамшигтай зүйлүүдийг хийсэн билээ. Тэр  
өвчтэй хүмүүсийг эдгээж, ядарч зовсон хүмүүсийн  
зүрх сэтгэлд амар тайвныг өгч мөн Бурхны үгийг  
зааж байв.**



**Маш олон хүн өвчнөөсөө ангижрахын  
тулд мөн тусламж гуйхаар Есүс уруу  
ирдэг байв.**



**Тэр түүнийг дагалдагч нарын дундаас арван  
хоёр эрийг Бурхны ажилд туслуулахын  
тулд өөртөө дагалдагчаар сонгов.**



**Хэрвээ та чухал  
сонголт хийх  
үедээ Бурханд  
залбирдаг уу?  
Тийм ээ Есүс ч  
залбирсан юм!  
Нам гүм ууланд  
очоод Есүс  
Тэнгэрт байгаа  
Эцэгтэйгээ  
ярьсан юм.**





**Есүс бүхэл  
шөнөжингөө  
залбирчээ.**




**Өглөө эрт Есүс түүнтэй хамт байгаа найз нар болон түүнийг дагадаг бүх хүмүүсийг дуудав. Тэр тэдний дундаас арван хоёрыг онцгойлон**

**сонгож элч нар гэж нэрлэв.**






**Есүс эхлээд Симон Петр болон түүний дүү Андрейг сонгов. Тэд Есүсийг анх дуудахад загасны ажлаа орхин түүнийг дагасан юм.**



**Зебедеен хөвгүүд болох  
Иаков Иохан нар ч түүнийг  
дагахаар загасны тороо  
орхижээ.**




**Есүс мөн Филип, Бартоломай, Матай, Томас,  
Алфайн хүү Иаков, Зеалот гэгдэх Симон,  
Иаковын хүү Иудас, урвагч  
болсон Искарриотын Иудас  
нарыг сонгосон юм.**



**Есүс сургаал заахдаа түүнийг үгийг сонсоод үүний дагуу үйлдэгч нь хадан дээр байшингаа барьсантай адил юм. Хүчтэй шуурга болсон ч байшин нурахгүй гэв.**



**Харин түүний үгийн дагуу үйлддэггүй хүн элсэн  
дээр байшингаа барьсантай адил юм. Шуурга  
болоход байшин нурах болно гэв.**



**Есүсийн сургаалууд нь амар зүйл биш байлаа.**

**"Хэрэв хэн нэгэн баруун хацрыг чинь алгадвал зүүн хацраа түүнд өг". "Дайснаа хайрла" хэмээн сургаж байв.**


**Хүмүүст Есүсийн хэлсний дагуу амьдрахын тулд Бурхны тусламж хэрэгтэй байв.**



**Есүс мөн хүмүүст  
харагдахгүйгээр залбир  
хүмүүсийн өмнө чанга  
дуугаар залбирдаг хуулийн  
багш нар шиг бүү бай гэв.**



**Есүс сургаалаа үргэлжлүүлэн Бурхан  
өөрт нь итгэдэг хүмүүсийг хооллож  
хувцаслах болно. Бурхан тэнгэрт  
дүүлэх шувуудыг хооллодог талын  
цэцгийг ч гоёмсгоор ургуулдаг тул  
өөрт нь итгэж байгаа хүмүүсийг  
хэрэгтэй бүхнээр нь хангах болно  
гэж байлаа.**






**Энэ өдөр Есүс сонгосон  
дагалдагч нартаа олон  
зүйлийг заав. Түүнийг  
сургаалаа зааж дуусахад  
уяман өвчтэй нэг хүн ирээд  
эдгээж өгөхийг хүсэв.**



**Есүс түүнд хариулж "Би хүсэж байна. Цэвэрш" гэв. Түүний дагалдагч нар болон бүх хүнийг үүнийг харж байв. Тэр эдгэрсэн байв! Зөвхөн Бурхны хүү л үүнийг хийж чадна. Дагалдагч нар нь тэдэнд гайхамшигтай**



**Эзэн байгааг  
МЭДЭВ.**



**Есүс арван хоёр дагалдагчаа сонгосон нь**


**Бурханы үг Библиээс авсан түүх**

**Матай 4-7, Марк 1, Лук 6**


**"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."**

**Дуулал 119:130**





39



60



**Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.**

**Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.**

**Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16**

